

**Б.БАЯСГАЛАН**

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Эрүүгийн
ял эдлүүлэх эрх зүйн
тэнхимийн ахлах
багш, дэд хурандаа*

ЯЛТНЫГ ХУЯГЛАН ХҮРГЭХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ялтныг хуяглан хүргэх ажиллагаа нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байдаг тодорхой цаг хугацаа, орон зайнд явагддаг хорих байгууллагын харуул хамгаалалтын нэг төрөл гэж үзэж байна.

Ялтныг хуяглан хүргэх эрх зүйн зохицуулалтын үндэс нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар “Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 хоногийн дотор аймаг, нийслэл дэх жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлэх ялтныг шууд, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд ял эдлэх ялтныг Дамжин өнгөрүүлэх ангид хүргэнэ.” 117 дугаар зүйлийн 117.2-д “Энэ хуулийн 117.1-д заасны дагуу Дамжин өнгөрүүлэх ангид ирсэн ялтан чухам аль ангид ял эдлэхийг Тогтоол гүйцэтгэх газар шийдвэрлэх ба ийнхүү гаргасан хуваарийн дагуу түүнийг ял эдлэх хорих ангид нь хүргэх асуудлыг Дамжин өнгөрүүлэх анги хариуцан гүйцэтгэнэ.” гэсэн заалт юм. Дээрхи хуулийн заалтыг

үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/130 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ялтныг хуяглан хүргэх заавар”-аар зохицуулагдан явагдаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 2013 онд “Тахарын албаны тухай хууль”-ийг батлан 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхтэй холбогдуулан яллагдагч, ялтныг хуяглан хүргэх чиг үүргийг Тахарын алба хэрэгжүүлэхээр болсон. Батлагдан гарсан хуулиас салбарлан эрх зүйн харилцаанд оролцогсдын харилцааг нарийвчлан зохицуулах эрх зүйн актууд гарахан зайлшгүй юм. Тахарын албаны хуяглан хүргэх ажиллагааны журам, эрх зүйн актыг гаргахдаа практик, амьдрал дээр тулгамдаж байгаа асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж судлаач нар үзэж байна.

“Ялтныг хуяглан хүргэх заавар”-ийн 2 дугаар зүйлийн 2.14-т “Хуяглан хуяглан хүргэх ажиллагааг орон нутаг, газар зүйн байршлаас шалтгаалан нисэх онгоц, төмөр замаар тээвэрлэж болно” гэж заасан ч өнөөдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Дамжин өнгөрүүлэх анги нь энэ үйл ажиллагааг хуяглан хүргэх ажиллагааны зориулалтаар дотоодоо тоногдсон ОХУ-д үйлдвэрлэсэн “УАЗ” фургон маркийн автомашиныг ашиглан гүйцэтгэж байна. Эдгээр автомашин нь нэг жилд 2500-3200 ялтныг 350-450 удаагийн тээвэрлэлтээр хорих анги хооронд хүргэж байгаа тоо баримт



судалгаанаас харагдаж байна. Энэхүү хуяглан хүргэх ажиллагааны харуул хамгаалалтыг “УАЗ” фургон маркын автомашины зохион байгуулалт, багтаамжаас шалтгаалан жолооч, хуяглан хүргэлтийн офицер, харуул хамгаалалтын ажилтан гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй явуулж 9-10 ялтныг нэг автомашинд өөр хооронд нь тусгаарлахгүйгээр тээвэрлэн явуулж байна. Энэ нь ялтан үгсэн тохиролцож албан хаагчийн амь биед халдах, дайрч довтлох магадлалтай юм. Тиймээс аюулгүй байдлыг хангах зорилгоор болон чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд ял эдлэх ялтнуудыг хуяглан хүргэх ажиллагаанд бугуйн гавыг тогтмол хэрэглэж байгаа. Тэгвэл энэ тусгай хэрэгсэл хэрэглэж

байгаа үйл ажиллагааг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” Монгол Улсын хууль, “Ялтныг хуяглан хүргэх заавар”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх журам”-д зохицуулж өгсөн ямар нэгэн зүйл заалт оруулаагүй байна.

Хуяглан хүргэх ажиллагаа нь зарим алслагдсан хорих ангиудад ялтан хүргэх үед 5-6 цагийн хугацаанд явагдаж байна. Практик үйл ажиллагаанд автомашинд техникийн саатал гарч ялтнуудыг автомашинаас буулгаж засвар хийх зайлшгүй шаардлага гардаг. Энэ тохиолдолд харуул хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах, аюулгүй байдлыг ямар аргаар хангах талаар заавар, журамд тодорхой тусгагдаагүй ч хуяглан хүргэх эрх бүхий албан тушаалтны тухайн үеийн шийдвэрээр зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд “УАЗ” фургонмаркийн автомашин ашиглаж байгаа нь дутагдалтай талууд байна гэж үзэж байна.

-Уг автомашин нь даац, багтаамж, хүчин чадлын хувьд орчин үеийн шаардлагын төвшинд хуяглан хүргэх зориулалтын дагуу тоногдох боломжгүй.

-Даац, багтаамжийн хувьд олноор тээвэрлэх боломжгүй тул олон дахин тээвэрлэх шаардлага гардаг.

-Гадаадын хөгжингүй орнуудын автомашинтай харьцуулж үзвэл эвдрэл, техникийн саатал харьцангуй их гардаг.

-Зуны улиралд агааржуулалт хувьд эрүүл ахуйн шаардлагыг хангадаггүй.

-“Ялтныг хуяглан хүргэх заавар”-т



тусгай бүлгийн ажилтнууд эмч, сувилагчийн хамт гүйцэтгэнэ гэж заагдсан боловч эдгээр ажилтнууд нь сууж явах зориулалтын суудал байхгүйгээс заавар зөрчин эмч, сувилагч ажилтнууд нь ялтнуудыг тээвэрлэх тасалгаанд сууж явахад хүрдэг зэрэг дутагдалтай талууд байгаа нь аюулгүй байдлыг бүрэн хангахгүй байна.

Өнөөдөр хөгжингүй гадаадын улс орнуудад хуяглан хүргэх ажиллагаанд маш өндөр зохион байгуулалттай хүн, хүчээс гадна орчин үеийн техник хэрэгсэл, тоног, төхөөрмжөөр тоноглогдсон автомашин, автобус ашиглаж байна.

Тухайлбал: АНУ, ОХУ-д ачааны автомашины тэвшний хэсэгт бүхээг суурилуулан тоноглогдсон автомашин, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс тусгай зориулалтын тоноглогдсон автобусаар хуяглан хүргэх үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Эдгээр ашиглаж байгаа автобус, автомашин нь хуяглан хүргэх үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа албан хаагч, ялтан, яллагдагчийн аюулгүй байдлыг хангасан сум үл нэвтрэх материалаар тоноглогдсон, ялтан, яллагдагч нэг бүрийг өөр хооронд нь тусгаарлсан тасалгаа, хяналт тавих теле камер, агааржуулах систем, бие засах тасалгаа зэргийг шийдвэрлэж өгсөн байна.

Иймээс дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тахарын албаны нэг чиг үүрэг нь яллагдагч, ялтныг хуяглан хүргэх чиг үүргийг хуульчилж өгсөн. Монгол Улсын хэмжээнд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх Тахарын

алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэсэн эрх бүхий субъект явуулна гэж үзэж энэ үйл ажиллагааг нарийвчлан судалж нэгдсэн нэг журам, заавраар зохицуулж байх.

2. Гадаадын улс орнуудад ялтан шилжүүлэх, шилжүүлэн авах орон нутагт яллагдагч, ялтныг нисэх онгоцоор хуяглан хүргэх тохиолдолд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтан тусгай хэрэгсэл биедээ авч явах, хэрэглэх талаархи эрх зүйн зохицуулалт одоогоор гараагүй байна. Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т “Орон нутгийн болон олон улсын нислэгийн тээвэрлэгч, үйлчлэгч байгууллага нь иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход шаардлагатай бүх арга хэмжээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ” гэж заасан. Иймд нисэх онгоцоор хуяглан хүргэхэд аюулгүй байдлыг хэрхэн хангах, зохион байгуулах талаар хууль эрхийн актанд тусгаж, зохицуулах шаардлагатай байна гэж үзэж байна.

3. Хорих байгууллага нь цаашид ялтныг хуяглан хүргэх үйл ажиллагааг дотоодоо явуулах нь тодорхой байгаа тул албан хаагч, ялтны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд гадаад улс орнуудын хуяглан хүргэх зориулалтаар тоноглогдсон автомашин, автобусыг ашиглах.



4. Хөгжингүй орнуудын тусгай тоноглогдсон тээврийн хэрэгслүүд нь өндөр үнэтэй, эдийн засгийн хувьд авч ашиглах боломжгүй гэж үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тахарын алба нь дотоод нөөц боломжоо ашиглан зорчигч тээврийн автобус, ачааны автомашиныг орчин үеийн жишигт нийцүүлэн тоноглож үйл ажиллагаандаа ашиглах.
5. Хөгжингүй орнуудын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, техник, зохион байгуулалтыг судалж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тахарын алба нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

**О.ПҮРЭВСҮРЭН**

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Эрүүгийн
ял эдлүүлэх эрх зүйн
тэнхимийн багш,
ахлах дэслэгч*

НИЙГМИЙН АЖИЛ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ҮЙЛ ЯВЦ

Мэргэжлийн удирдлагын зорилго

Нийгмийн ажил дахь мэргэжлийн удирдлагаар хангах үйл явц нь нийгмийн ажилтнуудад өөрсдийн мэдлэг чадвараа дайчлан, ажлаа үр нөлөө үр ашигтай гүйцэтгэхэд нь туслах асуудалд анхаарлаа хандуулдаг. Мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь “ерөнхийд нь ажиглах, хяналт тавих, харгалзах” гэсэн утгыг агуулна.

Харин нийгмийн ажилд энэхүү ойлголт нь мэргэжлийн удирдагчийн / Supervisor/ нийгмийн ажилтантай буюу удирдуулж байгаа хүнтэй харилцах харилцаанд гүйцэтгэх үүргийг тодорхойлоход хэрэглэнэ. Мэргэжлийн удирдагч болон удирдлуулж байгаа хүний хоорондох харилцаа нь ажилтны чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь боловсролын, удирдлагын болон боломж олгох чиглэлээр заах-сурах үйл явдал юм.

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцыг бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж болно. Мэргэжлийн удирдагчийн үүрэг бол